

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/189/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

"Голден пэйж Аудит" ХХК

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/23

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ойн сангийн нөөцийг тогтоох, бүс нутгийн хөгжлийн төлөв байдлыг тодорхойлохтой холбогдсон хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойд ой зохион байгуулалтын ажлыг хийх, улсын ойн менежментийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг улсын төсвөөс, хамгаалалтын бүс тогтоох болон ашиглалтын бүсийн ойд аймаг, сум, нийслэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгаас санхүүжүүлнэ гэж заасны дагуу тайлант онд 103,342.8 мянган төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019000091

Тухайн байгууллагын батлагдсан төсөв хүрэлцээгүйн улмаас үйл ажиллагаа явуулах материаллаг бааз суурь бэхжээгүй, дээд удирдлага анхаарал хандуулаагүй, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх үр дагавартай байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөр 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,146,807.53</u>	<u>32,721,807.53</u>
33	АВЛАГА	200,482.00	200,482.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,482.00	200,482.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,946,325.53	32,521,325.53
351	Түүхий эд материал	14,472,692.21	14,472,692.21
35110	Тусгай зориулалттай материал	14,472,692.21	14,472,692.21
354	Хангамжийн материал	17,473,633.32	18,048,633.32
35410	Бичиг хэргийн материал	842,850.00	1,087,850.00
35420	Аж ахуйн материал	6,105,833.32	6,105,833.32
35430	Сэлбэг хэрэгсэл	4,865,000.00	5,195,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,659,950.00	5,659,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>121,696,676.06</u>	<u>164,543,423.30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	121,696,676.06	164,543,423.30
392	Биет хөрөнгө	21,696,676.06	64,543,423.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,513,180.00	107,179,840.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,153,805.00)	(65,758,318.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,349,170.29	32,548,970.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,349,170.29)	(28,349,170.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,569,000.00	3,359,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,143,908.74)	(1,267,908.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,557,901.60	24,119,455.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,645,691.80)	(7,288,444.92)
393	Биет бус хөрөнгө	<u>100,000,000.00</u>	<u>100,000,000.00</u>
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(220,000.00)	(220,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	100,000,000.00	100,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>153,843,483.59</u>	<u>197,265,230.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>66,282.46</u>	<u>66,282.46</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	66,282.46	66,282.46
411	Богино хугацаат үнэт цаас	30,000.00	30,000.00
4112	Гадаад валют	30,000.00	30,000.00
41122	Бусад үнэт цаас	30,000.00	30,000.00
413	Өглөг	36,282.46	36,282.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,282.46	36,282.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>153,777,201.13</u>	<u>197,198,948.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	153,777,201.13	197,198,948.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	100,000,000.00	100,000,000.00
51101	Өмч: - төрийн	100,000,000.00	100,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	53,777,201.13	97,198,948.37
51210	Өмнөх үеийн үр дүн	53,777,201.13	53,777,201.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,421,747.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>153,843,483.59</u>	<u>197,265,230.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	66,146,600.00	155,571,014.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	52,228,214.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	52,228,214.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	52,228,214.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	52,228,214.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,146,600.00	103,342,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,146,600.00	103,342,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,146,600.00	103,342,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	76,416,693.55	112,149,266.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,416,693.55	112,149,266.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,337,558.46	110,397,005.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,057,365.17	69,010,374.05
210101	Үндсэн цалин	40,499,095.67	56,187,297.31
210102	Нэмэгдэл	689,296.55	4,537,215.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,624,000.00	2,360,000.00
210104	Урамшуулал	244,972.95	5,925,861.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,382,170.74	8,710,222.77
210201	Тэтгэврийн даатгал	3,398,806.55	5,922,951.44
210202	Тэтгэмжийн даатгал	660,929.16	696,817.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	350,601.73	557,454.28
210204	Ажилгүйдлийн даатгал	104,543.15	139,363.60
210205	Эрүүл мэндийн даатгал	867,290.15	1,393,635.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	851,454.00	2,808,517.61
210301	Гэрэл, цахилгаан	851,454.00	308,517.61
210302	Түлш, халаалт	-	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,982,400.00	10,729,570.00
210401	Бичиг хэрэг	337,400.00	429,570.00
210402	Тээвэр, шатахуун	4,520,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,513,600.00
210604	Урсгал засвар	-	1,513,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,134,000.00	1,092,000.00
210702	Дотоод албан томилолт	1,134,000.00	1,092,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,075.00	1,161,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	1,049,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	33,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,400.00	49,454.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,000.00	30,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,656,093.55	15,371,266.76
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,656,093.55	15,371,266.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,079,135.09	1,752,261.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	720,000.00	650,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000.00	650,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,359,135.09	1,102,261.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,359,135.09	1,102,261.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(10,270,093.55)</u>	<u>43,421,747.24</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(10,270,093.55)</u>	<u>43,421,747.24</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	66,146,600.00	103,342,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,146,600.00	103,342,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,146,600.00	103,342,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,183,500.00	97,353,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	57,067,464.91	95,600,738.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,067,464.91	95,600,738.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,067,464.91	95,600,738.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,057,365.17	69,079,596.82
210101	Үндсэн цалин	40,499,095.67	56,895,277.27
210102	Нэмэгдэл	689,296.55	4,537,215.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,624,000.00	2,360,000.00
210104	Урамшуулал	244,972.95	5,287,103.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,382,170.74	8,641,000.00
210201	Тэтгэврийн даатгал	3,398,806.55	5,875,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	660,929.16	691,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	350,601.73	553,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	104,543.15	138,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	867,290.15	1,382,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,851,454.00	2,808,517.61
210301	Гэрэл, цахилгаан	851,454.00	308,517.61
210302	Түлш, халаалт	1,000,000.00	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,982,400.00	10,974,570.00
210401	Бичиг хэрэг	337,400.00	674,570.00
210402	Тээвэр, шатахуун	4,520,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	386,000.00	1,843,600.00
210604	Урсгал засвар	386,000.00	1,843,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,134,000.00	1,092,000.00
210702	Дотоод албан томилолт	1,134,000.00	1,092,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,075.00	1,161,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,049,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	33,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,400.00	49,454.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,000.00	30,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	720,000.00	650,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	720,000.00	650,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000.00	650,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,359,135.09</u>	<u>7,092,061.57</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,989,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,989,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,989,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,989,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(5,989,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,396,035.09	1,102,261.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00	64,047,294.66	164,047,294.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	100,000,000.00	64,047,294.66	164,047,294.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(10,270,093.53)	(10,270,093.53)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00	53,777,201.13	153,777,201.13
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00	53,777,201.13	153,777,201.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	100,000,000.00	53,777,201.13	153,777,201.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	43,421,747.24	43,421,747.24
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,000,000.00	97,198,948.37	197,198,948.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,796,800.00	102,240,538.43	1,556,261.57	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,796,800.00	102,240,538.43	1,556,261.57	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,996,800.00	101,590,538.43	1,406,261.57	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,127,500.00	69,079,596.82	47,903.18	99.9
210101	Үндсэн цалин	62,574,600.00	56,895,277.27	5,679,322.73	90.9
210102	Нэмэгдэл	6,552,900.00	4,537,215.74	2,015,684.26	69.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,360,000.00	(2,360,000.00)	
210104	Урамшуулал	00.00	5,287,103.81	(5,287,103.81)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,641,000.00	8,641,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	5,875,800.00	5,875,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	691,300.00	691,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	553,000.00	553,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	138,300.00	138,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,382,600.00	1,382,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,130,000.00	2,808,517.61	321,482.39	89.7
210301	Гэрэл, цахилгаан	630,000.00	308,517.61	321,482.39	49.0
210302	Түлш, халаалт	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,174,900.00	10,974,570.00	200,330.00	98.2
210401	Бичиг хэрэг	674,900.00	674,570.00	330.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	300,000.00	200,000.00	60.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,843,600.00	156,400.00	92.2
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,843,600.00	156,400.00	92.2
2107	Томилолт, зочны зардал	1,146,400.00	1,092,000.00	54,400.00	95.3
210702	Дотоод албан томилолт	1,146,400.00	1,092,000.00	54,400.00	95.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,777,000.00	7,151,254.00	625,746.00	92.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,425,000.00	7,038,800.00	386,200.00	94.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	00.00	100,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	146,600.00	33,000.00	113,600.00	22.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	49,454.00	6,446.00	88.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	30,000.00	19,500.00	60.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800000.00	650000.00	150,000.00	81.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	650,000.00	150,000.00	81.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	650,000.00	150,000.00	81.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,796,800.00	103,342,800.00	454,000.00	99.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	103,796,800.00	103,342,800.00	454,000.00	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	103,796,800.00	103,342,800.00	454,000.00	99.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Батсүмбэр сум дундын ойн анги нь эрхэм зорилгоо “Ойн баялгийн нөөцийг тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээн, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойчдоо өвлүүлнэ гэсэн стратеги төлөвлөгөөтэй байна.

Төрөөс баримтлах бодлогын баримт тусгагдсан зорилт:

- Ногорн хөгжлийн бодлогын хүрээнд Байгалийн нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгон иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, ногоон хөгжлийн хэрэгжилтийг хангах
- Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Ойн менежментийг сайжруулах, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд захиргаа, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад удирдлагын манлайллыг хангаж, ил тод, авлига хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлэх гэжээ.

Батсүмбэр сум дундын ойн ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ойн тухай хууль нэмэлт өөрчлөлт
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,421.7 мянган төгрөгөөр буюу 28 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	200.5	200.5	-
Бараа материал	31,946.3	32,521.3	575.0
Үндсэн хөрөнгө	121,696.7	164,543.4	42,846.7
Нийт хөрөнгө	153,843.5	197,265.2	43,421.7
Өр төлбөр	66.3	66.3	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	153,777.2	197,198.9	43,421.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	153,843.5	197,265.2	43,421.7

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 575.0 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 42,846.7 мянган төгрөгөөр өссөн нь 5,989.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын А/543 дугаар тушаалаар шилжин ирсэн 52,228.2 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, хүлэмж зэрэг хөрөнгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 82,569.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16,127.5 мянган төгрөгөөр өсгөж, хангамжийн материалын зардлыг 3,658.5 мянган төгрөгөөр өсгөж баталсан байна. Энэ нь Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 21,227.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 103,796.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 103,342.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 102,240.5 мянган төгрөг буюу 98.5 хувьтай зарцуулж, 1,102.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Энэ нь гэрэл цахилгаан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71403	Ойжуулалт				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	102,696.8	102,542.8	154.0	99.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	800.0	650.0	150.0	81.3
80918	Бусад	300.0	-	300.0	-
	Дүн	103,796.8	103,192.8	604.0	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулах, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 76,416.7 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 1,146.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 112,149.3 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 1,261.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 625.7 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалыг 200.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 321.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 18,148.7 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 2,079.8 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа тул гүйцэтгэлээр давтан шалгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 563.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснийг зөвлөмж өгснийг 50 хувьтай хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	563.2	1	326.4	50
Нийт дүн	1	563.2	1	326.4	50

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллах талаар анхаарал хандуулах болно.

Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, ойн сангийн төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг сонсох, ойн талбайн хэмжээний нормативыг харгалзан нутаг дэвсгэртээ байх ойн ангийн жагсаалт, тухайн жилийн төсвийг батлах нь аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон засаг даргын бүрэн эрхийн асуудал болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 604.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 604.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын талаар холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлгүй 324.0 төгрөгийн гүйлгээ гарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ гэсэн заалтуудтай зөрчилдөж байна

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2. Өглөг, авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2018-2023 оны зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр 13.2 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй санхүүгийн тайланд тусгаагүй, 200.5 мянган төгрөгийн авлага, 66.3 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй өглөг авлага үүсгэн ажилласан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг, авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2018-2023 оны зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр 13.2 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй санхүүгийн тайланд тусгаагүй, 200.5 мянган төгрөгийн авлага, 66.3 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй өглөг авлага үүсгэн ажилласан	1	280.0					1	280.0				
Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлгүй 324.0 төгрөгийн гүйлгээ гарсан	1	324.0					1	324.0				
Дүн	2	604.0					2	604.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 18,148.7 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.	1	18,148.7			1	18,148.7		
Дүн	1				1	18,148.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн газрын хувь оролцоо санхүүгийн тайлангаар 100,000.0 мянган төгрөг, байгууллагын гэрчилгээгээр 13,546.0 мянган төгрөг буюу зөрүүтэй байна.	1						1	
Дүн	2				1	18,148.7	1	
Нийт дүн	2				1	18,148.7	1	



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 49-14510516-ТВА-2024/

Зуунмод

189/НА-СГА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Батсүмбэр сум дундын ойн ангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 18,148,700 /арван найман сая нэг зуун дөчин найман мянга долоон зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, 6 мэдээлэл хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4-д"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

018040810

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг² Батсүмбэр сум дундын ойн ангийн дарга Ш.Гантулга, нягтлан бодогч Ч.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

